



I-IV/2021

Тархаасан: 2021 оны 5 дугаар сарын 13



Улсын хэмжээнд 2021 оны эхний 4 сард 23.8 мянган эх амаржсан нь өмнөх оны мөн үеэс 1158 (4.6%)-аар буурсан байна. Амаржсан эхчүүдийн 17.8 мянга (75.0%) нь 6, түүнээс дээш удаа жирэмсний хяналтад хамрагдсан нь өмнөх оны мөн үеэс 736 (4.0%)-гаар буурчээ. Нийт амаржсан эхчүүдийн 65 (0.3%) нь гэртээ төрсөн нь өмнөх оны мөн үеэс 32 (33.0%)-оор буурсан байна.

Хүснэгт 1. Амаржсан эх, төрсөн хүүхэд, жил бүрийн эхний 4 сарын байдлаар


Үзүүлэлт	2018 I-IV	2019 I-IV	2020 I-IV	2021 I-IV	<u>2021 I-IV</u> <u>2020 I-IV</u>
Амаржсан эх	25 140	24 913	24 935	23 777	95.4
6, түүнээс дээш удаа хяналтад хамрагдсан	18 784	18 701	18 580	17 844	96.0
Гэрийн төрөлт	90	85	97	65	67.0
Амьд төрсөн хүүхэд	25 310	25 075	25 115	23 959	95.4
1 цагийн дотор хөхөө амласан хүүхэд	24 483	24 173	24 213	22 866	94.4
Төрөлхийн гажигтай төрсөн	166	219	224	196	87.5
2500 граммаас доош жинтэй төрсөн	1 146	1 060	1 171	929	79.3
Амьгүй төрсөн хүүхэд	129	140	140	121	86.4
Амьгүй төрөлтийн түвшин (1000 нийт төрөлтөд ногдох)	5	6	6	5	-

Эх үүсвэр: ЭМЯ-ны захиргааны мэдээлэл

Улсын хэмжээнд 2021 оны 4 дүгээр сард 6158 эх амаржиж, өмнөх сараас 158 (2.5%)-аар буурчээ. Амаржсан эхчүүдийн 4572 (74.2%) нь 6, түүнээс дээш удаа хяналтад хамрагдаж, өмнөх сараас 210 (4.4%)-аар буурсан байна. Амаржсан эхчүүдийн 17 (0.3%) нь гэртээ төрсөн бөгөөд өмнөх сараас 1 (5.6%)-ээр буурсан байна.

Зураг 1. Амаржсан эх, төрсөн хүүхэд, сараар, 2020-2021 он

▭ Амьд төрсөн хүүхэд (мян. хүүхэд)
 ▭ Амаржсан эх (мян.хүн)
 ▭ Амьгүй төрөлтийн түвшин (1000 нийт төрөлтөд ногдох)




Эх үүсвэр: ЭМЯ-ны захиргааны мэдээлэл

Эрүүл мэндийн яамны “Төрөлтийн цахим бүртгэл”-ээр 2021 оны 4 дүгээр сард 6026 эх амаржиж, 6099 хүүхдэд регистрийн дугаар олгожээ. Нийт төрсөн хүүхдийн 3148 нь эрэгтэй, 2951 нь эмэгтэй, 145 нь ихэр, хүүхдийн дундаж жин 3422 грамм, дундаж өндөр 50.8 см байна.


Амаржсан эхчүүдийн 3.7 хувь нь 20 хүртэлх насных, 92.0 хувь нь 20-39 насных, 4.3 хувь нь 40-өөс дээш насныхан байна.

Амаржсан эхчүүдийн 0.9 хувь нь боловсролгүй, 3.7 хувь нь бага, 12.6 хувь нь суурь, 34.4 хувь нь бүрэн дунд, 5.6 хувь нь техникийн болон тусгай мэргэжлийн, 41.1 хувь нь дипломын болон бакалаврын дээд, 1.7 хувь нь магистр, докторын зэрэгтэй байна. Амаржсан эхчүүдийн 54.3 хувь нь гэрлэлтээ албан ёсоор батлуулсан, 44.1 хувь нь гэрлэлтээ албан ёсоор батлуулаагүй, 1.6 хувь нь гэрлэлтээ цуцлуулсан байна.

Зураг 2. Амаржсан эх, насны бүлэг, дүнд эзлэх хувиар, дүнд эзлэх 2021 оны 4 дүгээр сар



Зураг 3. Амаржсан эхийн боловсролын түвшин, хувиар, 2021 оны 4 дүгээр сар



Эх үүсвэр: ЭМЯ-ны төрөлтийн цахим бүртгэл

Тайлбар: Энэхүү мэдээлэл нь ЭМЯ-ны захиргааны мэдээллээс тайлагнасан хугацааны хувьд өөр учир зөрүүтэй болно.

Улсын хэмжээнд 2021 оны эхний 4 сард 24.0 мянган хүүхэд төрсөн нь өмнөх оны мөн үеэс 1156 (4.6%)-гаар буурсан байна. Нийт амьд төрсөн хүүхдийн 22.9 мянга (95.4%) нь төрсний дараа 1 цагийн дотор хөхөө амласан бөгөөд өмнөх оны мөн үеэс 1347 (5.6%)-гоор буурчээ. Нийт амьд төрөлтийн 196 (0.8%) нь төрөлхийн гажигтай, 929 (3.9%) нь 2500 граммаас бага жинтэй байна. Амьгүй төрөлтийн түвшин 1000 нийт төрөлтөд 5 ногдож байна.

Харин 2021 оны 4 дүгээр сард 6207 хүүхэд амьд төрсөн нь өмнөх сараас 150 (2.4%)-аар буурчээ. Нийт амьд төрсөн хүүхдийн 5792 (93.3%) нь төрсний дараа 1 цагийн дотор хөхөө амласан нь өмнөх сараас 281 (4.6%)-ээр буурсан байна. Нийт амьд төрөлтийн 55 (0.9%) нь төрөлхийн гажигтай байгаа нь өмнөх сараас 12 (27.9%)-оор нэмэгдэж, 226 (3.6%) нь 2500 граммаас бага жинтэй байна. Амьгүй төрөлтийн түвшин 1000 нийт төрөлтөд 4 ногдож байна.

Улсын хэмжээнд 2021 оны эхний 4 сард нас баралтын 5253 тохиолдол бүртгэгдсэний 1480 (28.2%) нь эмнэлэгт, 3773 (71.8%) нь гэрийн (бусад газарт) нас баралт байна. Нийт нас баралт өмнөх оны мөн үеэс 13 (0.2%)-аар, эмнэлгийн нас баралт 15 (1.0%)-аа буурч, харин гэрийн (бусад газарт) нас баралт 2 (0.1%)-оор нэмэгджээ.

Хүснэгт 2. Нас баралт, эх, хүүхдийн эндэгдэл, жил бүрийн эхний 4 сарын байдлаар

Үзүүлэлт	2018	2019	2020	2021	2021 I-IV
	I-IV	I-IV	I-IV	I-IV	2020 I-IV
Нас баралт	5 717	5 735	5 266	5 253	99.8
Эмнэлэгт нас баралт	1 598	1 724	1 495	1 480	99.0
Гэртээ (бусад газарт)	4 119	4 011	3 771	3 773	100.1
Эхийн эндэгдэл	7	5	13	7	53.8
Тав хүртэлх насны хүүхдийн эндэгдэл	440	411	366	306	83.6
Нялхсын эндэгдэл	370	346	302	263	87.1
Нярайн эндэгдэл	233	205	184	188	102.2
Эхийн эндэгдлийн харьцаа	28	20	52	29	-
Тав хүртэлх насны хүүхдийн эндэгдлийн түвшин	17	16	15	13	-
Нялхсын эндэгдлийн түвшин	15	14	12	11	-
Нярайн эндэгдлийн түвшин	9	8	7	8	-

*Эх үүсвэр: ЭМЯ-ны захиргааны мэдээлэл*

Энэ оны 4 дүгээр сард нас баралтын 1484 тохиолдол бүртгэгдсэний 452 (30.5%) нь эмнэлэгт, 1032 (69.5%) нь гэрийн (бусад газарт) нас баралт байна. Нийт нас баралт өмнөх сараас 103 (7.5%)-аар, гэрийн нас баралт (бусад газарт) 31 (3.1%)-ээр, эмнэлгийн нас баралт 72 (18.9%)-оор тус тус нэмэгджээ.

Эхийн эндэгдэл 2021 оны эхний 4 сард 7 болж, өмнөх оны мөн үеэс 6 (46.2)-гаар буурчээ. Эхийн эндэгдлийн харьцаа (100 000 амьд төрөлтөд ногдох) 29 болж, өмнөх оны мөн үеэс 23-аар буурсан байна.

Улсын хэмжээнд 2021 оны эхний 4 сард нийт нас баралтын 5.8 хувийг 5 хүртэлх насны хүүхдийн эндэгдэл, 5 хүртэлх насны хүүхдийн эндэгдлийн 85.9 хувийг нялхсын эндэгдэл, нялхсын эндэгдлийн 71.5 хувийг нярайн эндэгдэл эзэлж байна. Тав хүртэлх насны хүүхдийн эндэгдэл 306 болж, өмнөх оны мөн үеэс 60 (16.4)-аар, нялхсын эндэгдэл 263 болж, 39 (12.9%)-өөр тус тус буурч, харин нярайн эндэгдэл 188 болж, 4 (2.2%)-өөр нэмэгдсэн байна.

Тав хүртэлх насны хүүхдийн эндэгдлийн түвшин 2021 оны эхний 4 сард 13 болж, өмнөх оны мөн үеэс 2-оор, нялхсын эндэгдлийн түвшин 11 болж, 1-ээр буурч, харин нярайн эндэгдлийн түвшин 8 болж, 1-ээр нэмэгдсэн байна.

Харин энэ оны 4 дүгээр сард тав хүртэлх насны хүүхдийн эндэгдлийн түвшин 15 болж, өмнөх сараас 4-өөр, нялхсын эндэгдлийн түвшин 12 болж, 2-оор, нярайн эндэгдлийн түвшин 8 болж, 1-ээр тус тус нэмэгдсэн байна.

Зураг 4. Хүүхдийн эндэгдлийн түвшин (1000 амьд төрөлтөд ногдох), сараар, 2020-2021 он



Эх үүсвэр: ЭМЯ-ны захиргааны мэдээлэл

Халдварт өвчнөөр өвчлөгчид 2021 оны эхний 4 сард 27.2 мянга болж, өмнөх оны мөн үеэс 15.2 мянга (2.3 дахин)-аар нэмэгдэхэд коронавирусын халдвараар өвчлөгчид 21.9 мянга (578.3 дахин)-аар нэмэгдсэн нь нөлөөлжээ.

Хүснэгт 3. Халдварт өвчин, төрлөөр, жил бүрийн эхний 4 сарын байдлаар

Үзүүлэлт	2018 I-IV	2019 I-IV	2020 I-IV	2021 I-IV	$\frac{2021 \text{ I-IV}}{2020 \text{ I-IV}}$
<b>Халдварт өвчнөөр өвчлөгчид</b>	<b>13 417</b>	<b>14 145</b>	<b>12 020</b>	<b>27 190</b>	<b>2.3<sup>1</sup></b>
Вирус хепатит	164	159	161	51	31.7
Сүрьеэ	1 267	1 222	1 246	780	62.6
Салхин цэцэг	2 960	4 149	1 633	104	6.4
Гар, хөл, амны өвчин	1 276	616	202	106	52.5
Цусан суулга	1 113	1 272	538	122	22.7
Тэмбүү	2 173	1 922	2 667	1 321	49.5
Гонококкт халдвар	1 644	1 757	2 006	1 113	55.5
Трихомониаз	1 517	1 454	1 817	995	54.8
ХДХВ/ДОХ	10	2	6	3	50.0
Мөөгөнцөр	576	548	1 307	484	37.0
Коронавируст халдвар	-	-	38	21 974	578.3 <sup>1</sup>

<sup>1</sup> Дахин

Эх үүсвэр: ЭМЯ-ны захиргааны мэдээлэл


Харин салхин цэцгээр өвчлөгчид 1529 (93.6%)-өөр, цусан суулгаар өвчлөгчид 416 (77.3%)-гаар, вирус хепатитаар өвчлөгчид 110 (68.3%)-аар, мөөгөнцрөөр өвчлөгчид 823 (63.0%)-аар, тэмбүүгээр өвчлөгчид 1346 (50.5%)-гаар, гар, хөл, амны өвчнөөр өвчлөгчид 96 (47.5%)-гаар, трихомониазаар өвчлөгчид 822 (45.2%)-оор, гонококкт халдвар 893 (44.5%)-аар, сүрьеэгээр өвчлөгчид 466 (37.4%)-гаар буурчээ.

Энэ оны 4 дүгээр сард нийт халдварт өвчний 15.9 мянган тохиолдол бүртгэгдсэн нь өмнөх сараас 8.6 мянга (2.2 дахин)-аар нэмэгдэхэд коронавирусын халдвараар өвчлөгчид 9.2 мянга (2.6 дахин)-аар нэмэгдэж, харин бусад өвчлөл 5-113 тохиолдол (2.7%-64.7%)-оор буурчээ.

Улсын хэмжээнд 2021 оны 4 дүгээр сард ХДХВ/ДОХ-ын тохиолдол илрээгүй бөгөөд нийт бүртгэгдсэн тохиолдол 314 байна.

## КОРОНАВИРУС ДЭЛХИЙ ДАХИНД


Зураг 5. Дэлхийн коронавирусын өвчлөл, нас баралтын тохиолдол, улс орноор, 2021 оны 4 дүгээр сарын байдлаар



Дэлхийн хэмжээнд 2020 оны 1 дүгээр сараас 2021 оны 4 дүгээр сард коронавирусын өвчлөлийн тохиолдол 223 улсад нийт 150.1 сая бүртгэгдэж, 3.2 сая хүн нас баржээ. Коронавирусын өвчлөлийн тохиолдол 2021 оны 4 дүгээр сард дэлхийн 212 улсад 22.2 сая бүртгэгдэж, өмнөх сараас 7.8 сая (53.6%) тохиолдлоор, нас баралтын тохиолдол 360.8 мянга бүртгэгдэж, 88.5 мянга (32.5%)-аар тус тус өсжээ.

Эх үүсвэр: ДЭМБ-ын мэдээлэл


Зураг 6. Дэлхийн хүн амын коронавирусын өвчлөл, нас баралтын тохиолдол, сараар, 2020-2021 он




Эх үүсвэр: ДЭМБ-ын мэдээлэл

Коронавирусын өвчлөлийн нийт тохиолдлыг дэлхийн улс орнуудын бүс нутгаар, 2021 оны 4 дүгээр сарын байдлаар харвал Зүүн өмнөд Азийн бүс нутаг хамгийн их буюу 31.6 хувь, хамгийн бага нь Африкийн бүсийн орнууд 1.0 хувь эзэлж байна.

Зураг 7. Дэлхийн хүн амын коронавирусын өвчлөлийн тохиолдол, бүс нутгаар, дүнд эзлэх хувиар, 2021 оны 4 дүгээр сар



Зураг 8. Дэлхийн хүн амын коронавирусын нас баралтын тохиолдол, бүс нутгаар, дүнд эзлэх хувиар, 2021 оны 4 дүгээр сар




Эх үүсвэр: ДЭМБ-ын мэдээлэл

Харин коронавирусын нас баралтын нийт тохиолдлын 45.0 хувь нь Америкийн бүс нутгийн орнуудад, хамгийн бага нь Африкийн бүсийн орнуудад 1.3 хувь бүртгэгджээ.

### Коронавирус Монгол Улсад

Монгол Улсад 2021 оны 4 дүгээр сарын байдлаар коронавирусын нийт 23.2 мянган тохиолдол бүртгэгдсэний 9.1 мянга (39.5%) нь эдгэрсэн байна. Нийт тохиолдлын 486 (2.1%) нь зөөвөрлөгдсөн, 22.7 мянга (97.9%) нь дотоодод тархсан халдвар байна.


Зураг 9. Коронавирусын халдвараар өвчлөгчид, нас баралт, аймаг, нийслэлээр, 2021 оны 4 дүгээр сарын байдлаар



Эх үүсвэр: ЭМЯ-ны захиргааны мэдээлэл

Өвчлөлийн тохиолдлыг аймгаар харвал төвийн бүсийн аймгуудад хамгийн их 1892 байгаа нь бусад бүсээс 677-1622 тохиолдол (35.8%-85.7%)-оор их, хамгийн бага нь зүүн бүсэд 270 байна. Өвчлөлийн тохиолдол Өмнөговь аймгаас бусад аймаг, нийслэлд бүртгэгдсэн байна.

Зураг 10. Коронавирусын халдвараар өвчлөгчид (10000 хүнд ногдох), бүсээр, 2021 оны 3 дугаар сарын байдлаар




Зураг 11. Коронавирусын халдвараар өвчлөгчид (10000 хүнд ногдох), бүсээр, 2021 оны 4 дүгээр сарын байдлаар




Улсын хэмжээнд коронавирусын өвчлөлийн 10000 хүнд ногдох түвшин 2021 оны 4 дүгээр сарын байдлаар 68 болж, өмнөх сараас 2.7 дахин, Улаанбаатар хотод 2.5 дахин, бусад бүсэд 3-18 дахин нэмэгджээ.

Коронавирусын нас баралтын тохиолдол 2021 оны 4 дүгээр сарын байдлаар улсын хэмжээнд 127 бүртгэгдсэний 124 нь Улаанбаатар, 2 тохиолдол нь Завхан, 1 тохиолдол нь Сүхбаатар аймагт байна.

Зураг 12. Коронавирусын тохиолдлын тоо, сараар, 2020-2021 он




Зураг 13. Коронавирусын тохиолдлын тоо, насны бүлэг, хүйсээр, 2021 оны 4 дүгээр сар



Эх үүсвэр: ЭМЯ-ны захиргааны мэдээлэл

Харин энэ оны 4 дүгээр сард коронавирусын 59 зөөвөрлөгдсөн, 14.7 мянган дотоодод тархсан халдвар, нийт 14.7 мянган тохиолдол илэрсэн нь өмнөх сараас 9.2 мянга (2.6 дахин)-аар нэмэгджээ. Коронавирусын нийт тохиолдлын 6893 (46.8%) нь эрэгтэй, 7831 (53.2%) нь эмэгтэй байна. Насны бүлгээр харвал 20-44 насныхан 6520 (44.3%), 45-аас дээш насныхан 4082 (27.7%), 0-19 насныхан 4122 (28.0%) байна.

Зураг 14. Коронавирусын вакцины хамралт, тун, хамрагдвал зохих хүн амд эзлэх хувиар, аймаг, нийслэлээр, 2021 оны 4 дүгээр сарын байдлаар



Эх үүсвэр: Халдварт өвчин судлалын үндэсний төв

Улсын хэмжээнд 2021 оны 4 дүгээр сарын байдлаар коронавирусын халдвараас сэргийлэх вакцинжуулалтын 1 дүгээр тунд 820.3 мянга буюу хамрагдвал зохих хүн амын 39.7 хувь, 2 дугаар тунд 340.7 мянга буюу хамрагдвал зохих хүн амын 16.5 хувь нь хамрагджээ. Улаанбаатар хотод вакцинжуулалтад хамрагдвал зохих хүн амын хувь улсын дунджаас 1-р тунгийн хамралт 29.9 пункт, 2 дугаар тунгийнх 17.3 пунктээр тус тус их байна. Дархан-Уул аймаг 1 дүгээр тунгийн хамралтын хувь хамгийн их 34.4 хувь, 2 дугаар тунгийн хамралтын хувь Өмнөговь аймагт хамгийн их 19.1 хувь байна.

### АРГАЧЛАЛЫН ТАЙЛБАР:

**Нярайн эндэгдлийн түвшин** (1000 амьд төрөлтөд ногдох): Тухайн жилд 0-28 хоногтой эндсэн хүүхдийн тоог амьд төрсөн хүүхдийн тоонд харьцуулж тооцно.

**Нялхсын эндэгдлийн түвшин** (1000 амьд төрөлтөд ногдох): Тухайн хугацаанд 1 хүртэлх насандаа эндсэн хүүхдийн тоог амьд төрсөн хүүхдийн тоонд харьцуулж тооцно.

**Тав хүртэлх насны хүүхдийн эндэгдлийн түвшин** (1000 амьд төрөлтөд ногдох): Тухайн хугацаанд 5 хүртэлх насандаа эндсэн хүүхдийн тоог амьд төрсөн хүүхдийн тоонд харьцуулж тооцно.

**Эхийн эндэгдлийн харьцаа** (100000 амьд төрөлтөд ногдох): Тухайн хугацаанд эндсэн эхийн тоог амьд төрсөн хүүхдийн тоонд харьцуулж тооцно.

**Амьд төрөлт:** Жирэмслэлтийн хугацаанаас хамаарахгүйгээр ердийн төрөлтөөр эсвэл мэс ажилбараар ургийг умайнаас гарган авсны дараа нярай амьсгалж байсан, эсвэл амьдын бусад ямар нэгэн шинж тэмдэг, өөрөөр хэлбэл, зүрхний цохилт, хүйний судасны лугшилт, булчингийн



тодорхой хөдөлгөөн илэрч байсан зэргийг (хүй эсвэл эхэсийг салгасан эсэхийг харгалзахгүй) хамруулна.

**Амьгүй төрөлт:** Жирэмсний 22 долоо хоног ба түүнээс хойших хугацаанд, 500 граммаас дээш жинтэй төрсөн нярайд амьдын шинж тэмдгийн аль нь ч (зүрхний цохилт, судасны лугшилт, булчингийн хөдөлгөөн) илрэхгүй байгааг хэлнэ.

**Эндсэн эх:** Жирэмсний хугацаанд болон төрөх үедээ эсвэл төрснөөс хойш 42 хоногийн дотор жирэмслэлтийн байрлал, үргэлжилсэн хугацаанаас үл хамааран жирэмслэлт, төрөлт болон түүнийг удирдахтай холбоо бүхий шалтгаанаар эндсэнийг хамруулна.

**Амьгүй төрөлтийн түвшин** (1000 нийт төрөлтөд ногдох): Тухайн хугацаанд нийт төрсөн хүүхдийн тоог амьгүй төрсөн хүүхдийн тоонд харьцуулж тооцно.

**Эх үүсвэр:** Эрүүл мэндийн яамны сарын мэдээ

**Ангилал, код:** Өвчний олон улсын ангилал /ICD-10/.

**Мэдээлэл авах линкүүд:**

<http://www.nso.mn/>

<http://www.1212.mn/>



**Дараагийн мэдээ тархаах хуваарь:** 2021 оны 6 дугаар сарын 17

*Хүн ам, нийгмийн статистикийн  
газрын дарга А.Амарбал  
Утас : (976-51)-264805*

*Хүн ам, нийгмийн статистикийн газрын  
статистикч Г.Урангоо  
Утас : (976-51)-263966*

